



УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Улаангом политехник коллежийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: УВА-2025/176/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:

www.audit.mn

Улаангом хот

2025 он

Увс аймаг дахь Төрийн аудитын газар,

Дарга, тэргүүлэх аудитор: М.Батсуурь

Утас: 70453317, Цахим хаяг: BatsuuriM@audit.gov.mn

Аудитын менежер: М.Бат-Амгалан

Утас: 70453799, Цахим хаяг: Bat-Amgalanm@audit.gov.mn

Ахлах аудитор: Т.Амармэнд

Утас: 70453721, Цахим хаяг: Amarmendt@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Ө.Бадрахын гудамж, Улаангом, Увс аймаг, 85165
Утас/Факс: 7045-3317

Цахим шуудан: uvs@audit.gov.mn

дэд. од. 25 № УВА-2025/1976/НА-СА-ТХЗ

танай _____ -ны № _____ -т

УЛААНГОМ ПОЛИТЕХНИК КОЛЛЕЖИЙН
ЗАХИРАЛ Д.БАТТОГТОХ ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Улаангом политехник коллежийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Улаангом политехник коллежийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Улаангом политехник коллежийн захирал нь Боловсрол шинжлэх ухааны сайдын "Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын багшид мэргэжлийн зэрэг олгох тухай" 2023 оны 06 дугаар сарын 28-ны өдрийн А/277 дугаар тушаалыг үндэслэн өөрөө өөртөө мэргэшлийн зэргийг нэмэгдлийг 15 хувиар тогтоож, нийт 2,486.9 мянган төгрөгийн нэмэгдэл цалин авсан, мэргэжлийн болон төгсөлтийн үнэлгээ, техникийн боловсролын диплом хамгаалалт, төгсөлтийн шалгалтад хяналт хэрэгжүүлсэн ажлын хэсэг, жимсний талбайн усалгааны ажил, тендер худалдан авах ажиллагаа зохион байгуулахад үнэлгээний багт ажилласан 37 иргэний ажлын цагийн хөлсөнд байгууллагын батлагдсан цалингийн сангаас 5,371.0 мянга, ажил олгогчоос төлөх шимтгэлд 599.3 мянга, нийт 5,970.3 мянган төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2020 оны 09 дүгээр сарын 14-ны өдрийн А/185 дугаар тушаалын гуравдугаар хавсралтаар баталсан мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын захиргааны удирдлага болон бусад ажилчдын орон тооны жишиг нормативаас илүү 2 орон тоотой ажиллаж (тооцооны нягтлан бодогч-1, нийгмийн ажилтан-1) цалин, урамшуулалд 48,067.8 мянган төгрөг, нийгмийн даатгалын шимтгэлд (ажил олгогчийн) 5,660.3 мянган төгрөг, нийт 53,728.1 мянган төгрөгийн зардлыг тус тус зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3 дахь заалтад "Санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх", 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх заалтад "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулна", 6.6.2 дахь заалтад "Төсвийн захирагч нь төсвийн асуудлаа өөрийн харьяалагдах дээд шатны төсвийн захирагчаар дамжуулан шийдвэрлүүлдэг байх", 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалтад "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", "Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсэгт

8525020379

“Албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэхдээ өөрийн болон өөртэй нь хамаарал бүхий этгээдийн хувийн ашиг сонирхлыг хөндсөн захиргааны шийдвэр гаргах, удирдах, хяналт, шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, гэрээ байгуулах, эдгээрийг хэлэлцэх, бэлтгэх, оролцох зэрэг үйл ажиллагаа явуулахыг хориглоно”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2.9 дэх заалтад “Энэ хуулийн үйлчлэлд хамаарах хуулийн этгээд, албан тушаалтан үйлдэл, эс үйлдэхүйн улмаас улсад учруулсан хохирол, зөрчлийн хариуцлагаа бүрэн хүлээдэг байх”, Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 5 дугаар хавсралт, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2020 оны 09 дүгээр сарын 14-ны өдрийн А/185 дугаар тушаалыг хэрэгжүүлэн ажиллаагүй нь нийцсэн бөгөөд зохистой батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2024 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн 583 дугаар тогтоолын дагуу 300 ортой оюутны дотуур байрны барилгыг хүлээн авч данс бүртгэлд тусгасан байна.

Аудитын гол асуудал

АДБОУС 2701.8-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх ажил гүйлгээ байхгүй болно.

Бусад асуудлын хэсэг

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад санхүүгийн тайлангийн тодруулга толилуулгад тусгаагүй, аудитын хамрах хүрээний хязгаарлалтын улмаас аудитын хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй асуудал гараагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



М.БАТСУУРЬ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1. Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	585,973,930.39	808,999,151.67
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	00.00	107,222,349.52
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	00.00	107,222,349.52
3121	Төгрөг	00.00	107,222,349.52
31211	Төрийн сангийн харилцах	00.00	107,222,349.52
33	АВЛАГА	20,252,373.24	12,270,117.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	284,387.96	2,059,020.00
335	Бусад авлага	19,967,985.28	10,211,097.00
3351	Байгууллагаас авах авлага	10,278,015.30	815,993.00
3352	Хувь хүмүүсээс авах авлага	9,689,969.98	9,395,104.00
35	БАРАА МАТЕРИАЛ	565,721,557.15	689,506,685.15
351	Түүхий эд материал	249,659,035.80	259,421,076.60
35110	Тусгай зориулалттай материал	248,497,857.80	258,259,898.60
35130	Эм боох материал	1,161,178.00	1,161,178.00
354	Хангамжийн материал	298,247,521.35	412,485,608.55
35410	Бичиг хэргийн материал	6,615,800.00	5,066,000.00
35420	Аж ахуйн материал	11,032,810.00	12,300,510.00
35430	Сэлбэг хэрэгсэл	3,355,000.00	9,679,000.00
35440	Түлш, шатах тослох материал	198,000.00	00.00
35450	Барилгын засварын материал	100,578,344.00	118,193,396.60
35460	Хүнсний материал	23,226,144.00	16,788,480.00
35470	Бусад хангамжийн материал	153,241,423.35	250,458,221.95
35600	Мал амьтад	17,815,000.00	17,600,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	5,397,538,144.88	12,261,973,339.28
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	5,397,538,144.88	12,261,973,339.28
392	Биет хөрөнгө	4,585,643,344.88	11,414,998,539.28
39201	Барилга, байгууламж, орон сууц	3,831,337,659.00	10,636,097,659.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-449,952,644.68	-509,610,695.11
39203	Авто-тээврийн хэрэгсэл	218,428,925.00	280,428,925.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-105,075,508.48	-121,222,133.59
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	1,211,770,821.85	1,438,562,360.85
39206	Хуримтлагдсан элэгдэл	-403,932,794.54	-622,898,016.56
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	303,413,968.55	347,487,667.55
39208	Хуримтлагдсан элэгдэл	-107,266,187.11	-138,698,213.76
39214	Бусад үндсэн хөрөнгө	184,814,230.80	200,277,230.80
39215	Хуримтлагдсан элэгдэл	-178,391,532.51	-179,950,451.90
39217	Ном	80,496,407.00	84,524,207.00
393	Биет бус хөрөнгө	811,894,800.00	846,974,800.00
39301	Программ хангамж	29,857,703.20	29,857,703.20
39302	Хуримтлагдсан элэгдэл	-29,857,703.20	-29,857,703.20
39303	Бусад биет бус хөрөнгө	811,894,800.00	846,974,800.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	5,983,512,075.27	13,070,972,490.95
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	73,051,249.00	2,749,436.77

41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	73,051,249.00	2,749,436.77
413	Өглөг	73,051,249.00	2,749,436.77
4136	Бусад өглөг	73,051,249.00	2,749,436.77
41361	Байгууллагад төлөх өглөг	73,051,249.00	2,749,436.77
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	5,910,460,826.27	13,068,223,054.18
51	Засгийн газрын хувь оролцоо	5,910,460,826.27	13,068,223,054.18
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	4,315,315,463.70	4,315,315,463.70
51101	Өмч: - төрийн	4,315,315,463.70	4,315,315,463.70
512	Хуримтлагдсан үр дүн	-718,477,583.60	6,439,284,644.31
51210	Өмнөх үеийн үр дүн	-718,477,583.60	-718,477,583.60
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	7,157,762,227.91
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	2,313,622,946.17	2,313,622,946.17
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	5,983,512,075.27	13,070,972,490.95

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	4,503,994,169.53	12,781,358,677.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	798,446,349.53	7,214,751,277.00
120	Нийтлэг татварын бус орлого	798,446,349.53	7,214,751,277.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	798,446,349.53	7,214,751,277.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	25,408,804.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	22,959,500.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	798,446,349.53	7,166,382,973.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,705,547,820.00	5,566,607,400.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	3,251,255,700.00	4,739,735,900.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	3,251,255,700.00	4,739,735,900.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	54,203,320.00	00.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	54,203,320.00	00.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	400,088,800.00	826,871,500.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	400,088,800.00	826,871,500.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	3,946,366,786.25	5,623,596,449.09
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,946,366,786.25	5,623,596,449.09
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,693,180,824.05	5,271,770,276.17
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,259,468,525.00	3,304,753,777.00
210101	Үндсэн цалин	1,478,780,986.00	1,988,859,769.00
210102	Нэмэгдэл	554,610,947.00	1,102,867,317.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	73,663,966.00	72,654,014.00
210104	Урамшуулал	152,412,626.00	140,372,677.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	283,180,097.96	408,252,864.22
210201	Тэтгэврийн даатгал	196,392,385.21	284,529,311.36

210202	Тэтгэмжийн даатгал	23,090,741.32	32,235,926.02
210203	ҮОМШӨ-ний даатгал	18,239,131.29	17,245,422.83
210204	Ажилгүйдлийн даатгал	4,120,660.12	14,419,531.53
210205	Эрүүл мэндийн даатгал	41,337,180.02	59,822,672.48
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	462,071,767.83	659,176,480.15
210301	Гэрэл, цахилгаан	39,635,542.13	45,925,603.85
210302	Түлш, халаалт	378,619,135.70	556,956,260.30
210303	Цэвэр, бохир ус	43,817,090.00	56,294,616.00
2104	Хангамж, бараа материалын зардал	116,587,395.00	47,882,607.20
210401	Бичиг хэрэг	3,199,000.00	14,862,055.00
210402	Тээвэр, шатахуун	8,886,200.00	10,538,500.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,150,680.00	2,884,984.20
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	544,000.00	00.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,568,130.00	19,597,068.00
210408	Бараа материал акталсны зардал	94,239,385.00	00.00
2105	Нормативт зардал	143,263,553.00	152,081,120.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	2,780,800.00	1,453,600.00
210502	Хоол, хүнс	104,346,998.00	137,748,520.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	36,135,755.00	12,879,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	90,575,650.00	39,329,750.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	6,100,000.00	10,285,000.00
210604	Урсгал засвар	84,475,650.00	29,044,750.00
2107	Томилолт, зочны зардал	5,242,000.00	28,857,950.00
210701	Гадаад албан томилолт	1,136,000.00	00.00
210702	Дотоод албан томилолт	4,106,000.00	28,857,950.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	8,966,606.00	39,557,149.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,770,000.00	4,135,260.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	5,616,000.00	34,523,952.00
210803	Даатгалын үйлчилгээ	103,350.00	249,780.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	172,500.00	209,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	66,000.00	66,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	598,000.00	00.00
210807	Газрын төлбөр	640,756.00	373,157.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	323,825,229.26	591,878,578.60
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	325,840.00	2,300,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	176,840,680.28	261,817,735.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	146,658,708.98	327,760,843.60
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	253,185,962.20	351,826,172.92
2132	Бусад урсгал шилжүүлэг	228,721,149.00	290,831,333.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	16,044,000.00	00.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	101,492,993.00	30,797,833.00

213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	105,785,286.00	247,882,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	5,398,870.00	12,151,500.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	23,227,559.00	00.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	23,227,559.00	00.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	1,237,254.20	60,994,839.92
213401	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт төсөвт байгууллага	1,068,203.33	00.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	169,050.87	60,994,839.92
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	557,627,383.28	7,157,762,227.91
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	39,839,349.69	00.00
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	39,839,349.69	00.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-39,839,349.69	00.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	517,788,033.59	7,157,762,227.91

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	3,705,753,317.00	5,615,270,569.98
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	00.00	48,663,169.98
120	Нийтлэг татварын бус орлого	00.00	48,663,169.98
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	00.00	48,663,169.98
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	25,408,804.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	23,254,365.98
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,705,753,317.00	5,566,607,400.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	3,251,255,700.00	4,739,735,900.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	3,251,255,700.00	4,739,735,900.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	54,293,320.00	00.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	54,293,320.00	00.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	400,088,800.00	826,871,500.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	400,088,800.00	826,871,500.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	115,497.00	00.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	115,497.00	00.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	3,640,219,757.00	5,363,787,320.46
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,640,219,757.00	5,363,787,320.46
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,388,327,027.80	5,014,518,687.54
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,259,468,525.00	3,305,520,803.23
210101	Үндсэн цалин	1,478,791,317.00	1,989,193,995.23

210102	Нэмэгдэл	553,746,275.00	1,102,867,317.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	73,661,839.00	72,654,014.00
210104	Урамшуулал	153,269,094.00	140,805,477.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	283,203,296.67	408,219,670.03
210201	Тэтгэврийн даатгал	196,415,583.92	284,496,024.45
210202	Тэтгэмжийн даатгал	23,090,741.32	32,236,018.74
210203	ҮОМШӨ-ний даатгал	18,239,131.29	17,245,422.83
210204	Ажилгүйдлийн даатгал	4,120,660.12	14,419,531.53
210205	Эрүүл мэндийн даатгал	41,337,180.02	59,822,672.48
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	342,103,799.13	722,439,860.08
210301	Гэрэл, цахилгаан	39,635,542.13	43,314,967.08
210302	Түлш, халаалт	258,651,167.00	622,830,277.00
210303	Цэвэр, бохир ус	43,817,090.00	56,294,616.00
2104	Хангамж, бараа материалын зардал	22,278,900.00	00.00
210401	Бичиг хэрэг	4,487,750.00	00.00
210402	Тээвэр, шатахуун	4,953,500.00	00.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,150,680.00	00.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,344,000.00	00.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	8,342,970.00	00.00
2105	Нормативт зардал	144,408,390.00	139,716,300.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	3,245,800.00	00.00
210502	Хоол, хүнс	104,286,590.00	139,716,300.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	36,876,000.00	00.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	93,670,350.00	78,438,800.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,059,600.00	00.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	21,950,000.00	35,002,000.00
210604	Урсгал засвар	70,660,750.00	43,436,800.00
2107	Томилолт, зочны зардал	7,903,450.00	00.00
210701	Гадаад албан томилолт	1,136,000.00	00.00
210702	Дотоод албан томилолт	6,767,450.00	00.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	8,845,306.00	00.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,770,000.00	00.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	5,616,000.00	00.00
210803	Даатгалын үйлчилгээ	103,350.00	00.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	172,500.00	00.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	64,700.00	00.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	478,000.00	00.00
210807	Газрын төлбөр	640,756.00	00.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	226,445,011.00	360,183,254.20
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,294,940.00	138,076,188.20
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	225,150,071.00	222,107,066.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	251,892,729.20	349,268,632.92
2132	Бусад урсгал шилжүүлэг	227,427,916.00	288,273,793.00

213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	115,497.00	00.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	16,044,000.00	00.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	101,492,993.00	30,797,833.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	105,652,786.00	247,882,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,122,640.00	9,593,960.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	23227559.00	0.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	23,227,559.00	00.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	1,237,254.20	60,994,839.92
213401	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт төсөвт байгууллага	1,068,203.33	00.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	169,050.87	60,994,839.92
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	65,533,560.00	251,483,249.52
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	65,533,560.00	144,260,900.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	65,533,560.00	144,260,900.00
2200	Дотоод эх үүсвэрээр	65,533,560.00	144,260,900.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	65,533,560.00	144,260,900.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-65,533,560.00	-144,260,900.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	107,222,349.52
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	107,222,349.52

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2023 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	4,315,315,463.70	2,349,402,181.24	-1,272,044,852.26	00.00	5,392,672,792.68
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	35,779,235.07	00.00	35,779,235.07
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	4,315,315,463.70	2,349,402,181.24	-1,236,265,617.19	00.00	5,428,452,027.75
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	517,788,033.59	00.00	517,788,033.59
C08	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	4,315,315,463.70	2,313,622,946.17	-718,477,583.60	00.00	5,910,460,826.27
D01	2024 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	4,315,315,463.70	2,313,622,946.17	-718,477,583.60	00.00	5,910,460,826.27
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	4,315,315,463.70	2,313,622,946.17	-718,477,583.60	00.00	5,910,460,826.27
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	35,080,000.00	00.00	00.00	00.00	35,080,000.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	7,157,762,227.91	00.00	7,157,762,227.91
D09	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	4,350,395,463.70	2,313,622,946.17	6,439,284,644.31	00.00	13,068,223,054.18

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан /Улсын төсөв/

/төгрөгөөр/

ЭЗА	Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл			
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	4,763,300,300.00	4,681,176,720.46	82,123,579.54
21	УРСГАЛ ЗАРДАЛ	4,763,300,300.00	4,681,176,720.46	82,123,579.54
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4,474,597,100.00	4,392,902,927.46	81,694,172.54
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	3,307,240,700.00	3,305,520,803.23	1,719,896.77
210101	Үндсэн цалин	2,089,840,700.00	1,989,193,995.23	100,646,704.77
210102	Нэмэгдэл	1,115,091,800.00	1,102,867,317.00	12,224,483.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	102,308,200.00	72,654,014.00	29,654,186.00
210104	Урамшуулал	00.00	140,805,477.00	140,805,477.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	413,405,100.00	408,219,670.03	5,185,429.97
210201	Тэтгэврийн даатгал	281,115,500.00	284,496,024.45	-3,380,524.45
210202	Тэтгэмжийн даатгал	33,072,400.00	32,236,018.74	836,381.26
210203	ҮОМШӨ-ний даатгал	16,536,200.00	17,245,422.83	-709,222.83
210204	Ажилгүйдлийн даатгал	16,536,200.00	14,419,531.53	2,116,668.47
210205	Эрүүл мэндийн даатгал	66,144,800.00	59,822,672.48	6,322,127.52
2105	Нормативт зардал	144,420,000.00	139,716,300.00	4,703,700.00
210502	Хоол, хүнс	144,420,000.00	139,716,300.00	4,703,700.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	52,227,700.00	51,869,200.00	358,500.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	6,500,000.00	6,249,500.00	250,500.00
210602	Тавилга	10,680,400.00	10,617,700.00	62,700.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	35,047,300.00	35,002,000.00	45,300.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	557303600.00	487576954.20	69,726,645.80
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	255,897,100.00	187,729,988.20	68,167,111.80
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	301,406,500.00	299,846,966.00	1,559,534.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	288703200.00	288273793.00	429,407.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	288,703,200.00	288,273,793.00	429,407.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	30,937,200.00	30,797,833.00	139,367.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	247,882,000.00	247,882,000.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	9,884,000.00	9,593,960.00	290,040.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	4,776,935,900.00	4,788,399,069.98	-11,463,169.98
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	4,739,735,900.00	4,739,735,900.00	00.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	4,739,735,900.00	4,739,735,900.00	00.00
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	37,200,000.00	48,663,169.98	-11,463,169.98
120004 1	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	24,340,500.00	25,408,804.00	-1,068,304.00

120004 2	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	12,859,500.00	23,254,365.98	-10,394,865.98
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	107,222,349.52	107,222,349.52
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	122.00	123.00	-01.00
620001	Удирдах ажилтан	03.00	03.00	00.00
620002	Гүйцэтгэх ажилтан	89.00	89.00	00.00
620003	Үйлчлэх ажилтан	30.00	31.00	-01.00

2.6 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан /Орон нутгийн төсөв/

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл			
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	826,871,500.00	765,876,660.08	60,994,839.92
21	УРСГАЛ ЗАРДАЛ	826,871,500.00	765,876,660.08	60,994,839.92
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	826,871,500.00	765,876,660.08	60,994,839.92
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	783,382,800.00	722,439,860.08	60,994,839.92
210301	Гэрэл, цахилгаан	64,594,900.00	43,314,967.08	21,279,932.92
210302	Түлш, халаалт	624,722,500.00	622,830,277.00	1,892,223.00
210303	Цэвэр, бохир ус	94,065,400.00	56,294,616.00	37,770,784.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	43,488,700.00	43,436,800.00	51,900.00
210601	Багаж, техник, хэрэгсэл			
210604	Урсгал засвар	43,488,700.00	43,436,800.00	51,900.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	826,871,500.00	826,871,500.00	
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	826,871,500.00	826,871,500.00	
132001	Орон нутгийн төсвөөс	826,871,500.00	826,871,500.00	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл			
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл			

ГУРАВ. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 65,969.2 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс аудитын явцад 2,308.8 мянган төгрөгийн 2 алдааг залруулж, 739.7 мянган төгрөгийн 1 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 5,970.3 мянган төгрөгийн 1 зөрчилд алдаа зөрчлийг таслан зогсоох 1 албан шаардлага, 56,950.4 мянган төгрөгийн алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж өглөө.

Залруулсан алдаа:

1. Улаангом политехник коллеж нь тайлант онд авто машины даатгалын төлбөрт 249.8 мянган төгрөг зарцуулсныг санхүүгийн үр дүнгийн бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардалд тайлагнасан нь Үнэн зөв байх батламж мэдэгдлийг хангахгүй байсан тул залруулга хийлгэлээ.

2. Аудитын явцад Улаангом политехник коллежийн хүнсний бараа материалын үлдэгдэлд тооллого хийхэд дутагдсан 1,040.8 мянган төгрөгийн бараа материал, 2024 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн Б/04 дүгээр цалин шинэчлэн баталсан тушаалын хавсралтад багш М.Чинзоригт зэргийн нэмэгдлийг батлаагүй байхад 1, 2, 3 дугаар сард зэргийн нэмэгдлийг 10 хувиар тооцон нийт 381.9 мянга, сахилгын шийтгэлийн хугацаа дуусаагүй байхад үр дүнгийн урамшуулалд 432.8 мянга, багш М.Нандин-эрдэнэд илүү олгосон 203.5 мянган төгрөгийн цалинг санхүүгийн тайланд авлагаар бүртгэж залруулга хийлгэлээ.

5.1 Төлбөрийн акт

Улаангом политехник коллежийн захирлын 2024 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн Б/13 дугаар тушаалаар дотуур байрны үйлчлэгч Ю.Уламбаяр, 2024 оны 07 дугаар сарын 25-ны өдрийн Б/30 дугаар тушаалаар барилгын мэргэжлийн багш Г.Рагчаа нарыг өндөр насны тэтгэвэрт гарахад олгох тэтгэмжийг зөрүүтэй тооцон 739.7 мянган төгрөгийг илүү олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3 дахь заалтад “Санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх”, 6 дугаар зүйлийн 6.4.1-д “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулна”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2.9 дэх заалтад “Энэ хуулийн үйлчлэлд хамаарах хуулийн этгээд, албан тушаалтан үйлдэл, эс үйлдэхүйн улмаас улсад учруулсан хохирол, зөрчлийн хариуцлагаа бүрэн хүлээдэг байх”, Засгийн газрын 2019 оны 7 дугаар тогтоолын 2.1-д “Нэг удаагийн буцалтгүй тусламж тооцох үндсэн цалингийн хэмжээг тогтоохдоо тухайн албан тушаалын үндсэн цалингийн сүүлийн 3 жилийн дунджаар тооцно” гэж заасныг хэрэгжүүлэн ажиллаагүй нь нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Илүү олгосон тэтгэмжийн 739.7 мянган төгрөгийг төлүүлэхээр төлбөрийн акт тогтоолоо.

5.1 Албан шаардлага

Улаангом политехник коллежийн нь мэргэжлийн болон төгсөлтийн үнэлгээ, техникийн боловсролын диплом хамгаалалт, төгсөлтийн шалгалтад хяналт хэрэгжүүлсэн ажлын хэсэг, жимсний талбайн усалгааны ажил, тендер худалдан авах ажиллагаа зохион байгуулахад үнэлгээний багт ажилласан 37 иргэний ажлын цагийн хөлсийг байгууллагын батлагдсан цалингийн сангаас 5,371.0 мянга, ажил олгогчоос төлөх шимтгэлд 599.3 мянга, нийт 5,970.3 мянган төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3 дахь заалтад “Санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх”, 6 дугаар зүйлийн 6.4.1-д “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулна”, 16 дугаар зүйлийн 16.5.3 дахь заалтад “Батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг тогтоох”, 16.5.5 дахь заалтад “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” гэж заасныг хэрэгжүүлэн ажиллаагүй нь нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Алдаа зөрчлийг таслан зогсоох давтан гаргахгүй байх албан шаардлага өглөө.

5.3 Зөвлөмж-1

1. Цалин тогтоолттой холбоотой.

Илрүүлэлт:

Улаангом политехник коллежийн захирал нь Боловсрол шинжлэх ухааны сайдын “Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын багшид мэргэжлийн зэрэг олгох тухай” 2023 оны 06 дугаар сарын 28-ны өдрийн А/277 дугаар тушаалыг үндэслэн 2024 оны

01 дүгээр сарын 24-ний өдрийн Б/04 дүгээр, 2024 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн Б/14 дүгээр, 2024 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн Б/50 дугаар тушаалуудаар цалинг шинэчлэн тогтоохдоо өөрөө өөртөө мэргэшлийн зэргийг нэмэгдлийг 15 хувиар тогтоож нийт 2,486.9 мянган төгрөгийн цалин авсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3 дахь заалтад “Санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх”, 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх заалтад “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулна”, 6.6.2 дахь заалтад “Төсвийн захирагч нь төсвийн асуудлаа өөрийн харьяалагдах дээд шатны төсвийн захирагчаар дамжуулан шийдвэрлүүлдэг байх”, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсэгт “Албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэхдээ өөрийн болон өөртэй нь хамаарал бүхий этгээдийн хувийн ашиг сонирхлыг хөндсөн захиргааны шийдвэр гаргах, удирдах, хяналт, шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, гэрээ байгуулах, эдгээрийг хэлэлцэх, бэлтгэх, оролцох зэрэг үйл ажиллагаа явуулахыг хориглоно”, Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 5 дугаар хавсралтаар батлагдсан Төрийн үйлчилгээний албан хаагчид мэргэшлийн зэргийн нэмэгдэл олгох нийтлэг журмын журмын 2.-д “Төрийн үйлчилгээний албан хаагчийг мэргэжлийнхээ дагуу тухайн албан тушаал эрхэлж байх хугацаанд мэргэшлийн зэргийн нэмэгдэл олгох шалгуур үзүүлэлтийг үндэслэн албан тушаалын сарын үндсэн цалингаас дор дурдсан хувиар бодож сар бүр олгоно”, “Цэцэрлэгийн багш, арга зүйч, ерөнхий боловсролын сургуулийн багш, сургалтын менежер, албан бус боловсролын болон мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын багш” гэж заасныг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж:

Цаашид Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх заалтад “Төсвийн захирагч нь төсвийн асуудлаа өөрийн харьяалагдах дээд шатны төсвийн захирагчаар дамжуулан шийдвэрлүүлдэг байх”, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсэгт “Албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэхдээ өөрийн болон өөртэй нь хамаарал бүхий этгээдийн хувийн ашиг сонирхлыг хөндсөн захиргааны шийдвэр гаргах, удирдах, хяналт, шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, гэрээ байгуулах, эдгээрийг хэлэлцэх, бэлтгэх, оролцох зэрэг үйл ажиллагаа явуулахыг хориглоно” гэж заасныг мөрдөж ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Увс аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 04 дүгээр сарын 30 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Зөвлөмж-2

1. Цалин урамшуулалтай холбоотой.

Илрүүлэлт:

Улаангом политехник коллежийн захирлын 2024 оны 06 дугаар сарын 28-ны өдрийн Б/28 дугаар “Урамшуулал олгох тухай” тушаалаар Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2 дахь хэсэгт “Нягтлан бодох бүртгэлийн ажилд үр бүтээл гарган ажилласан нягтлан бодох бүртгэлийн ажилтныг шагнаж урамшуулж болно” гэж заасны дагуу нягтлан бодогч Б.Эрдэнэсүрэнд 2 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний буюу 2,942.0 мянган төгрөгийн урамшуулал цалин олгосон нь Засгийн газрын 2019 оны 05 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Төрийн албан хаагчид шагнал олгох журам”-ын 3.3-д “Мөнгөн шагналыг төрийн онцгой чухал буюу онц төвөгтэй албан даалгавар биелүүлсэн, төрийн байгууллагын үйл ажиллагаа, төрийн үйлчилгээг сайжруулах чиглэлээр шинэ санал, санаачилга гаргаж хэрэглээнд нэвтрүүлсэн төрийн албан хаагчид олгож болно. Байгууллагын удирдлагын шийдвэрээр тухай

ажилтныг шагнах мөнгөн шагналын хэмжээ нь сарын үндсэн цалинг 1.5 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хүртэл хэмжээтэй байна” гэж зааснаас 735.5 мянган төгрөгөөр хэтрүүлэн олгосон байна.

Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2 дахь хэсэгт заасны дагуу шагнал, урамшуулал олгохдоо Засгийн газрын 2019 оны 05 дугаар тогтоолыг мөрдөж ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Увс аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 06 дугаар сарын 10 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Зөвлөмж-3

1. Орон тоотой холбоотой.

Илрүүлэлт:

Улаангом политехник коллежийн нь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2020 оны 09 дүгээр сарын 14-ны өдрийн А/185 дугаар тушаалын гуравдугаар хавсралтаар баталсан мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын захиргааны удирдлага болон бусад ажилчдын орон тооны жишиг нормативаас илүү 2 орон тоотой ажиллаж (тооцооны нягтлан бодогч-1, нийгмийн ажилтан-1) цалин, урамшуулалд 48,067.8 мянган төгрөг, нийгмийн даатгалын шимтгэлд (ажил олгогчийн) 5,660.3 мянган төгрөг, нийт 53,728.1 мянган төгрөгийн зардал гаргасан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3 дахь заалтад “Батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг тогтоох”, 16.5.5 дахь заалтад “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх хэсэгт “Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно”, 15.1.2 дахь заалтад “Чиг үүрэг, орон тоог давхардуулан тогтоох”, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2020 оны 09 дүгээр сарын 14-ний өдрийн А/185 дугаар тушаалын 3 дугаар хавсралтыг хэрэгжүүлэн ажиллаагүй байна.

Өгсөн зөвлөмж:

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3 дахь заалтад “Батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг тогтоох”, 16.5.5 дахь заалтад “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2020 оны 09 дүгээр сарын 14-ны өдрийн А/185 дугаар 3 дугаар хавсралтыг баримтлан бүтэц орон тоог шинэчлэн батлах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Увс аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 04 дүгээр сарын 30 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

ДӨРӨВ. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Тайлант онд авто машины даатгалын төлбөрт 249.8 мянган төгрөгийн гарсныг санхүүгийн үр дүнгийн бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардалд тайлагнасан					1	249.8	1	249.8				

Аудитын явцад Улаангом политехник коллежийн хүнсний бараа материалын үлдэгдэлд тооллого хийхэд 1,040.8 мянган төгрөгийн бараа материал дутагдсаныг, Багш М.Чинзоригт зэргийн нэмэгдлийг 381.9 мянга, сахилгын шийтгэлийн хугацаа дуусаагүй байхад урамшуулал гэж 432.8 мянга, багш М.Нандин-эрдэнийн цалинг 203.5 мянга, нийт 1018.2 мянган төгрөгийн цалин, урамшуулал илүү олгосныг санхүүгийн авлагад дансанд 2,059.0 мянган төгрөгөөр бүртгэн залруулга хийлгэв.					1	2,059.0	1	2,059.0				
Нийт дүн					2	2,308.8	2	2,308.8				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны Тоо	Тоо	Дүн
Улаангом политехник коллежийн захирлын 2024 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн Б/13 дугаар тушаалаар дотуур байрны үйлчлэгч Ю.Уламбаяр, 2024 оны 07 дугаар сарын 25-ны өдрийн Б/30 дугаар тушаалаар барилгын мэргэжлийн багш Г.Рагчаа нарт өндөр насны тэтгэвэрт гарахад олгох тэтгэмжийг зөрүүтэй тооцон 739.7 мянган төгрөгийг илүү олгосон байна.			1	739.7								
Улаангом политехник коллежийн нь мэргэжлийн болон төгсөлтийн үнэлгээ, техникийн боловсролын диплом хамгаалалт, төгсөлтийн шалгалтад хяналт хэрэгжүүлсэн ажлын хэсэг, жимсний талбайн усалгааны ажил, тендер худалдан авах ажиллагаа зохион байгуулахад үнэлгээний багт ажилласан 37 иргэний ажлын цагийн хөлсийг байгууллагын батлагдсан цалингийн сангаас 5,371.0 мянга, ажил олгогчоос төлөх шимтгэлд 599.3 мянга нийт 5,970.3 мянган төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан байна.					1	5,970.3						
Улаангом политехник коллежийн захирал нь Боловсрол шинжлэх ухааны сайдын "Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын багшид мэргэжлийн зэрэг олгох тухай" 2023 оны 06 дугаар сарын 28-ны өдрийн А/277 дугаар тушаалыг үндэслэн 2024 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн Б/04 дүгээр, 2024 оны 04 дүгээр							1	2,486.9				

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Өөрчлөлтгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1				1		
2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС								
4	ТТЗ								
5	ТЕЗ								
	НИЙТ	1	1				1		

АУДИТЫН ТАЙЛАН

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

БЭЛТГЭСЭН:

АУДИТОР



/М.БАТСУУРЫ/

/М.БАТ-АМГАЛАН/

/Т.АМАРМЭНД/

2025 оны 02 дугаар сарын 25-ны өдөр